



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/373

Хэрлэн сум

“Алтаргана-2024” наадмын
зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.6.4 заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Алтаргана-2024” наадмын зардалд 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Олон улсын чанартай Алтаргана наадмыг тогтмол зохион байгуулна” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны дугаар сарын 09-ны өдрийн дугаар захирамжийн хавсралт

“АЛТАРГАНА-2024” ОЛОН УЛСЫН XV ИХ НААДАМД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Наадамд оролцогчдын хоолны зардал	ш	61	66,000	4,026,000	/1өдөр *16500/, 4 өдөр, 4*16500=66.000₮
2	Байрны зардал		61	120,000	7,320,000	/1өдөр*30.0000/, 4 өдөр, 4*30.0000=120.000₮
3	Автобус /шатахууны зардал/	л	800	3,700	2,960,000	100км-44л гэж үзээд ирж очих 1600км
4	Ачааны машин /шатахууны зардал/	л	290	2,550	739,500	100км-18л гэж үзээд ирж очих 1600км
5	Фургон авто машин /2 ш/	л	580	2,550	1,479,000	100км-18л гэж үзээд ирж очих 3200км 2 авто машинаар тооцов
6	Жолоочын томлилт	х	4	170,000	2,720,000	Наадамд оролцогч нарын ачаа, авто машины 4 жолоочын албан томлилтын зардал
7	Тогоочийн хөлс	х	4	200,000	800,000	Наадамд оролцогч нарын хоол хийх 2 тогоочын цалин
НИЙТ					20,044,500	

“АЛТАРГАНА-2024” НААДМЫН ОРОЛЦОГЧДЫН ТОО

№	Наадмын төрөл	Оролцогчдын тоо
1	Хүндэт зочид, зохион байгуулагч	8
2	Буриад ардын дуу	8
3	Орчин үеийн буриад дуу	3
4	Буриад яруу найраг	2
5	Үлгэрч, ерөөлч, магтаалч	2
6	Дангина гоо бүсгүй	2
7	Ардын гар урлалын үзэсгэлэн	4
8	“Буриад хувцас: Уламжлал ба орчин үе”	2
9	Буриадын нэг өдөр	6
10	Уран сайхны гэрэл зураг	1
11	“Нангин бууса” Буриадын аж амьдрал, ахуйг харуулсан уралдаан	1
12	Хөгжимчид	4
13	Шатар	1
14	Сээр шалгах	4
15	Ширээний шагай	6
16	Бөх	5
НИЙТ ДҮН		61